



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 117 дугаар тушаал, 2014 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 07/2014 тоот мэдэгдэл, 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 01/31 тоот мэдэгдэл, “Хүннү эмпайр” хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Эм даблью ти эс” хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын арилжаанд оролцох эрхийг сэргээлгэх тухай хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хүннү эмпайр” ХХК, “Эм даблью ти эс” ХХК-иудын арилжаанд оролцох эрхийг 9 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг энэ тушаалын 1-т заасан гишүүн компаниудад анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР